

**САНГИЙН ЯАМНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТАЙЛАН**

№	Хийх ажил		Хэрэгжүүлсэн арга хэмжээ
<b>Тулгуур 1. Ёс зүйтэй манлайлал</b>			
<b>Зорилт 1 Авлигаас урьдчилан сэргийлэх, шударга ёсыг тогтоох</b>			
1	Яамны удирдлагаас авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар гаргасан уриалгыг хэрэгжилтийг идэвхжүүлэх	АТГ-ын холбогдох ажилтнаар мэдээллийн цагаар мэдээлэл хийлгүүлэх	“Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг”, “их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлэг”-ийн бүрдүүлэлтийн талаар АТГ-аас ажилтан урьж, мэдээлэл хийлгэх. , “Албан тушаалтны ХАС болон ХОМ-ийн цахим программд мэдүүлэг хэрхэн бөглөх анхаарах асуудлын талаар АТГ-ын комиссар Л.Анхныбаяр, Мөнхбаяр нараар 2 удаа яамны нийт ажилтан албан хаагчдад мэдээлэл хийлгэлээ.
<b>Тулгуур 2. Хувь хүний шударга байдал</b>			
<b>Зорилт 2. Шударга ёс, эрхэмлэх зүйлс болон ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх</b>			
	Шинээр орсон болон хамрагдаагүй ажиллагсадыг ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхаа илэрхийлсэн хуудсанд гарын үсэг зуруулж, баталгаажуулах	Ажилд шинээр томилогдсон ажилтнуудад тогтмол танилцуулж гарын үсэг зуруулах	 <p>Төлөвлөгөөт ажлын хүрээнд яамны нийт 158 төрийн захиргааны албан хаагч мөн 19 гэрээт ажилтанаар авлига, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байхаа илэрхийлж, илэрхийлэх хуудсанд гарын үсэг зуруулж баталгаажуулж байна.</p> <p>Шинээр томилогдсон төрийн захиргааны албан хаагчдад авлига ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх илэрхийлэх хуудсанд гарын үсэг зуруулах ажлыг тогтмол зохион байгуулах болно.</p>
	Ажлын байрны тодорхойлолтонд шударга ёсны шалгуур, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар тодорхой заалт оруулах арга хэмжээг хэвшүүлэх	Яамны нийт ажилтан, албан хаагчид болон шинээр ажилд томилогдсон ажлын байрны тодорхойлолтонд авилгаас ангид байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар заалт оруулахарга хэмжээг тогтмол гүйцэтгэх	Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоол, <b>Сангийн яамны авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх</b> зорилгоор яамны бүх ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчилэн боловсруулах ажлыг хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 12 дугаар сарын 03-ны АЗ47 дугаар тушаалаар байгуулан, бүх хүний ажлын байрны тодорхойлолтын “Тусгай шаардлага” хэсэгт: - Албан тушаалтан нь хууль дээдлэх зарчимд захирагдан, албан үүргээ иргэдийн итгэл хүлээхүйц, тэгш, шударга, хариуцлагатайгаар гүйцэтгэж, албаны ёс зүйг сахина.

		<ul style="list-style-type: none"> <li>- Албан тушаалын бүрэн эрхээ өөрийн болон өөртэйгөө нь хамаарал бүхий этгээдийн хувийн зорилгод ашиглахгүй бөгөөд албан үүрэгтээ нөлөөлөхүйц аливаа харилцаанаас ангид байна.</li> <li>- Иргэн болон хуулийн этгээдийн зүгээс тавьсан албан үүрэгтэйгээ зөрчилдөх хувийн ашиг сонирхлын асуудал болон зан байдлыг тэвчиж, албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн ашиг сонирхлыг хувийн болон тусгай ашиг сонирхлоос илүүд үзнэ.</li> <li>- Ашиг сонирхлын зөрчилд орж болох нөхцөл байдлыг мэдэгдэх, түүнээс татгалзах замаар урьдчилан сэргийлнэ гэсэн заалтууд орууллаа.</li> </ul>
--	--	---

**Зорилт 3. Ажилтнуудын ёс зүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх талаар сургалт, семинар, зөвлөгөөн зохион байгуулах**

<p>Авлига, хээл хахуулийн нийгмийн хор уршиг, түүнийг хэрхэн таслаж байгаа талаарх онол, практикийн талаар мэдээлэл хийлгэх</p>	<p>-АТГ-аас холбогдох мэргэжилтнийг урьж мэдээлэл зохион байгуулах</p>	<p>“Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг”, “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг”, “их хэмжээний өөрчлөлтийн мэдүүлэг”-ийн бүрдүүлэлтийн талаар АТГ-аас ажилтан урьж, мэдээлэл хийлгэх. , “Албан тушаалтны ХАС болон ХОМ-ийн цахим программд мэдүүлэг хэрхэн бөглөх анхаарах асуудлын талаар АТГ-ын комиссар Л.Анхныбаяр, Мөнхбаяр нараар 2 удаа яамны нийт ажилтан албан хаагчдад мэдээлэл хийлгэлээ.</p>
---	--	--

**Тулгуур 3. Тогтолцооны шударга байдал**

**Зорилт 4. Авлигыг үүсгэж болзошгүй дүрэм журмыг хянах, хариуцлагын тогтолцоо бий болгох**

<p>Сангийн яамны системийн хэмжээнд мөрдөгдөж буй хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм журмыг нягтлан үзэж шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох ажлыг зохион байгуулах</p>	<p>Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд батлан гаргадаг дүрэм, журмын талаар түүнийг хэрэглэгч байгууллага, иргэдийг хамруулсан судалгаа явуулж, түүний үр дүнд хүнд суртал, чирэгдэл учруулж байгаа дүрэм журмыг тодорхойлж, боловсронгуй болгох, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох ажлыг зохион байгуулах</p>	<p>Сангийн сайдын болон Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан эрх зүйн харилцаа бий болгож буй актуудад Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын мэргэжилтэн А.Даваажаргал, Ц.Батзул нар дүн шинжилгээ хийж үзлээ. Дүн шинжилгээгээр яамны системийн хэмжээнд мөрдөгдөж буй хүнд суртал, чирэгдэл учруулсан дүрэм журам одоогоор байхгүй гэж дүгнэлээ.</p> <p>Мөн яамны нээлттэй хаалганы өдрөөр тус ямаар үйлчлүүлж буй иргэдийн дунд судалгааны маягт тараан бөглүүлж үзэхэд одоогоор чирэгдэлтэй үйл ажиллагаа дурдагдаагүй байна.</p> <p>Мөн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан Сангийн сайдын тушаалуудыг хүчинтэй эсэхээр нь цэгцлэж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан эсэхээс үл хамааран иргэд, байгууллагын хүсэлтийг харгалзан холбогдох дүрэм, журам, заавар зэргийг баталсан хүчин төгөлдөр тушаалуудыг байршуулж, хүчингүй болсон тушаалуудыг хассан. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан удирдамжийг баримтлан загвар хүснэгтийн дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн, хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээ тогтоосон 1992 оноос хойшхи шийдвэрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан</p>
--	---	--

			<p>мэдээг ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Сангийн сайдын дангаар болон бусад салбарын сайдтай хамтран баталсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тушаалуудыг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “<b>ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМ</b>”- д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, улсын нэгдсэн дугаар тавигдсан дардастай тушаалын хувийг Яамны архивт нэгдсэн байдлаар анх удаа 2011 оноос эхлэн өгч байгаа бөгөөд цаашид жил бүр архивлаж байна. Сангийн яам нь цахим архивтай болсон тул эдгээр эрхийн актыг сонирхсон иргэн шууд танилцах нөхцөл бүрдэж байгаа.</p>
	<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр явуулах талаар судлах, хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх</p>	<p>Цахим худалдан авалт, төсвийн ил тод цахим хуудас, нягтлан бодох бүртгэлийн e-balance-ийг шинэчлэн ажиллуулах арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр явуулах талаар судлах, хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Сангийн яам нь улсын хэмжээнд ашиглах бүрэн боломжтой, нийт хэрэглэгчидэд зориулсан дараах 5 томоохон цахим хуудсаар төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон эдийн засгийн холбогдолтой бүхий л мэдээллийг ил тод, шуурхай мэдээлж байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <a href="http://www.mof.gov.mn">www.mof.gov.mn</a></li> <li>2. <a href="http://www.e-procurement.mn">www.e-procurement.mn</a></li> <li>3. <a href="http://www.iltod.gov.mn">www.iltod.gov.mn</a></li> <li>4. <a href="http://www.tusuv-oronnutag.mn">www.tusuv-oronnutag.mn</a></li> <li>5. <a href="http://www.e-balance.gov.mn">www.e-balance.gov.mn</a></li> </ol> <p><i>Эдгээр цахим хуудсын багтаамжийг өргөжүүлснээр төсвийн болон худалдан авах ажиллагаа, гадаадын зээл, тусламжийн холбогдолтой мэдээ, мэдээлэл болон зарим гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомж, дүрэм, журмыг тогтмол мэдээлэх өргөн боломж нээгдэж ард иргэдэд ил тодоор хүрэх болсон.</i></p> <p>Яамны цахим хуудсанд “Монгол Улсын Нэгдсэн Түрүүлэгч Индикатор, Засгийн газрын үнэт цаасны арилжааны мэдээ, үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлийн мэдээ”, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй гүйцэтгэл, түүний дараалал, санхүүжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг СМТХ-тэй хамтран яамны 1 давхарт байрлах цахим самбараар байнга мэдээллэн ажиллаж байна.</p> <p>гэсэн тайлангуудын боловсруулан яамны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээллэн ажиллаж байна.</p> <p><b><a href="http://iltod.gov.mn">iltod.gov.mn</a></b> цахим хуудаснаа, 2014 оны батлагдсан төсөв, 2014 оны төсвийн нэмэлт өөрчлөлт, тодотгол, Төсвийн сар улирлын хуваарийн өөрчлөлтийг Сангийн сайдын тушаалаар хуваарьт өөрчлөлт орсон тухай бүрд, Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн мэдээг сар, улирлын давтамжтайгаар, Монгол улсын 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийн тухай</p>

хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан тухай мэдээлэл, 2015 оны Монгол улсын төсвийн зарлагын хязгаарын төсөл, Монгол улсын 2015 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хууль, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг УИХ-д өргөн барьсан тухай мэдээлэл;

**[www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)** Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдаж буй бүх тендер шалгаруулалт нь **[www.e-procurement.mn](http://www.e-procurement.mn)** вэб сайтад зарлагдаж, тендер шалгаруулалтын үр дүнг тендер шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгжүүд болон шалгарсан, шалгараагүй үндэслэлийн талаар тухай бүрт нь тус сайтаар нийтэд мэдээлж байна. Мөн **[www.meps.gov.mn](http://www.meps.gov.mn)** вэб сайтыг ажиллуулж худалдан авах ажиллагааны цаасан хэлбэрээс цахим хэлбэрт шилжүүлэн ажиллуулж байна.

**[www.tusuv-oronnutag.mn](http://www.tusuv-oronnutag.mn)** ОНХС-ийн системийг 2013 оны 10 сард бий болгож, эхний туршилтыг зарим аймгуудад хийж шаардлагатай засвар өөрчлөлтийг оруулж сайжруулсан юм. Үүний үндсэн дээр ОНХС-ийн системийг ашиглах талаар сургалтыг Сангийн яамнаас бүх аймаг, нийслэлд 2013 оны 10, 11 саруудад амжилттай зохион байгууллаа. Уг сургалтад аймаг, нийслэл, дүүргийн санхүү, төрийн сангийн болон хөгжлийн бодлогын хэлтсийн мэрэгжилтнүүд, сумдын төрийн сангийн төлөөлөгч нар зэрэг нийт 4200 орчим ажилтныг хамруулан системийг хэрхэн ашиглах дэлгэрэнгүй зааварчилгаа өгсний хамт тухайн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2013 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг системд бүрэн орууллаа.

Энэхүү сургалтад зориулж Сангийн яам болон аймаг, сумдын 3 түвшний хэрэглэгчдийн ашиглах гарын авлагыг Дэлхийн банкны санхүүжилтээр хэвлүүлэн сургалтын зорилгоор тараасан. Сургалтын явцад ОНХС-ын хөрөнгөөр орон нутагт хэрэгжиж буй 6462 төсөл, арга хэмжээ, тэдгээрийн санхүүжилтийн байдал, гүйцэтгэгч нэрс, тендер зарласан байдал зэрэг мэдээллүүд системд бүрэн орсон байна.

Орон нутаг 2014 оны төсвөө баталмагц орон нутгийн хөгжлийн сангийн жагсаалтаа энэхүү системд шууд оруулах боломжтой болсон бөгөөд Сангийн яамнаас ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалт, санхүүжилтийг ил тод, шударга болгох талаар онцгой анхаарч ажиллаж байгааг тэмдэглэхийг хүсч байна. нутгийн хөгжлийн

**[www.e-balance.gov.mn](http://www.e-balance.gov.mn)** Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн хүрээнд Санхүүгийн тайлангийн И-баланс програмыг шинэчлэн сайжруулахаар 2012 оны 11 дүгээр сарын 29-ноос эхлэн Интерактив Би Ай ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

			<p>Шинэчилсэн И-баланс програмыг Сангийн яамны мэдээллийн баазад суурилуулах ажлыг 2013 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хийж, аж ахуйн нэгж, байгууллагын 2013 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг шинэчилсэн маягт болон шинэчилсэн програмаар 2013 оны 4 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хянаж, хүлээн авлаа. Шинэ програм хангамжийг ашигласнаар зөвхөн нэг төрлийн тайлангийн маягтаар хүлээн авч байсныг өөрчилж, байгууллагуудын үйл ажиллагааны онцлог байдлаар төрөлжүүлэн төрийн бус байгууллага, банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани, үнэт цаасны мэргэжлийн төрлөөр системд оруулах боломжтой болсон ба тус тусын загварын санхүүгийн тайлан, тодруулгын мэдээллийг гар аргаар шивэх, компьютерийн файл хэлбэрээр системд оруулах, импортлох боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн Сангийн яамны нэгжүүд болон бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл харилцан солилцох, санхүүгийн шинжилгээний тайлан (салбар, үйл ажиллагааны чиглэл, өмчийн хэлбэрээр төрөл бүрийн шинжилгээний болон харьцуулалтын тайлан) гарах зэрэг боломжууд бий болсон.</p> <p>Мөн гэрээт ажлын хүрээнд Интерактив Би Ай ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг ажил үүргийн хуваарьт заасан 44 шаардлагын дагуу шалгаж, зохих тестүүдийг хугацааны давтамжтайгаар хийж хэрэглэгчийн шаардлагын хэсгийг тестлэн эцэслэж Санхүүгийн тайлангийн И-баланс програмын акт хүлээлцэх баримтанд 2013 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Интерактив Би Ай ХХК хамтран гарын үсэг зурлаа.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн төсвийн мэдээллийг ард иргэдэд ил тод байлгах зорилгоор санаачлан батлуулсан <b>Шилэн дансны</b> хуулийг хэрэгжүүлэх үүрэг нь Сангийн яамны харьяалах асуудлын хүрээнд хамаарах ба тус хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Шилэн дансны журмын төслийг боловсруулан холбогдох газруудаас санал авахаар хүргүүлээд байна. Шилэн дансны нэгдсэн системийг бий болгох талаар судалгааны ажлыг эхлүүлсэн бөгөөд Шилэн дансны хуулийн дагуу Шилэн дансны нэгдсэн системийг 2016 оны 6 дугаар сарын 30-нд бэлэн болгохоор ажлын төлөвлөгөө боловсруулж байна.</p>
	<p>Бараа ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээний үүргээ биелүүлээгүй нь нотлогдсон иргэн, хуулийн этгээдийг хар жагсаалтанд бүртгэх</p>	<p>Эрх бүхий байгууллагад хандан холбогдох мэдээллийг нэгтгэсэн байх</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.5-д заасны дагуу худалдан авах ажиллагаанд оролцоходоо гэрээний үүргээ биелүүлээгүй, ноцтой зөрчсөн, авлигын гэмт хэрэгт холбогдсон, хуурамч материал ирүүлсэн зэргийг эрх бүхий улсын байцаагчийн тогтоосны дагуу Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 49 тоот тушаал, 2014 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 162 тоот тушаалуудаар нийт 42 аж ахуйн нэгжүүдийг тендерт оролцогчийн эрхийг хязгаарласан этгээдүүдийн бүртгэлд хамрууллаа.</p> <p>Дэлгэрэнгүйг <a href="http://mof.gov.mn/ШИЛЭН_ДАНС/">http://mof.gov.mn/ШИЛЭН_ДАНС/</a> Хар жагсаалт хэсэг болон <a href="http://www.e-procurement.mn">www.e-procurement.mn</a> сайтаас харна уу.</p>

**Зорилт 5. Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах**

<p>Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийн бодлогын ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах</p>	<p>Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн <b>143</b> дугаар тогтоолоор баталсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны <b>“Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”</b>-ийг Сангийн яам үйл ажиллагаандаа хэрхэн хэрэгжүүлж байгааг 2013 оны байдлаар гаргаж, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолын дагуу хяналт-шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгсөн байна. “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн биелэлтийг <b>2013</b> оны байдлаар яамны холбогдох газруудаас гаргуулан авч Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 2014 оны 3 дугаар сард хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өглөө.</p> <p>Дээрх тогтоолоор төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг илтгэх 34 шалгуур үзүүлэлтийн хэрэгжилт <b>90.8</b> хувьтай байгаа тул <b>“Хангалттай”</b> гэж үнэлэв. 2014 оны хэрэгжилтийг 2015 оны эхний улиралд гарган хяналт-шинжилгээ хийнэ.</p> <p>Мөн Сангийн яамны цахим хуудсанд байршуулсан Сангийн сайдын тушаалуудыг хүчинтэй эсэхээр нь цэгцлэж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ агуулсан эсэхээс үл хамааран иргэд, байгууллагын хүсэлтийг харгалзан холбогдох дүрэм, журам, заавар зэргийг баталсан хүчин төгөлдөр тушаалуудыг байршуулж, хүчингүй болсон тушаалуудыг хассан. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ын дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан удирдамжийг баримтлан загвар хүснэгтийн дагуу улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн, хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээ тогтоосон 1992 оноос хойшхи шийдвэрүүдэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан мэдээг ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Сангийн сайдын дангаар болон бусад салбарын сайдтай хамтран баталсан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тушаалуудыг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан <b>“ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭ ТОГТООСОН ШИЙДВЭР ГАРГАХ ЖУРАМ”</b>- д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, улсын нэгдсэн дугаар тавигдсан дардастай тушаалын хувийг Яамны архивт нэгдсэн байдлаар анх удаа 2011 оноос эхлэн өгч байгаа бөгөөд цаашид жил бүр архивлаж байна. Сангийн яам нь цахим архивтай болсон тул эдгээр эрхийн актыг сонирхсон иргэн шууд танилцах нөхцөл бүрдэж байгаа.</p>
--	--	--

Хүний нөөцийн ил тод байдлыг тухайд “Сангийн яамны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр “2007-2016 он”, Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг /2010-2011он/ Төрийн нарийн бичгийн даргын 2006 оны 180 дугаар тушаалаар батлуулж, өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.3-д тусгагдсаны дагуу Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааны талаар болон ажилд томилох, чөлөөлөх тухай гарсан тушаалуудыг “Дотоод мэдээллийн нэгдсэн систем”-д тавьж яамны ажилтнуудад мэдээлж байна. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр нь хүний нөөцийн удирдлагын процесст оролцох бүх субъектэд /яамны удирдлага, ажилтан албан хаагчид бүрт/ зориулагдах бөгөөд субъектүүд нь хүний нөөцийн талаарх шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх, зохицуулах, зохион байгуулах, дэмжихэд оролцох чиг үүрэгтэй байхаар тусгасан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.3-д тусгагдсаны дагуу Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааны талаар болон ажилд томилох, чөлөөлөх, зэрэг дэв олгох зэрэг гарсан бүх тушаалуудыг яамны дотоод сүлжээнд Хүний нөөц хэсэгт байршуулан тавьж яамны ажилтнуудад мэдээлж байна. Одоогоор тус хэсэгт 2013-2014 оны 500 орчим тушаал байгаа болно.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу эхний ээлжинд яаманд ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар нөхөх зарчмыг баримталж байна. Уг хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавьж зохин зөвшөөрөл авч томилж байгаа болно. Мөн Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан 3 удаагийн тохиолдолд яамны ажилтан албан хаагчдын дунд нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулж, өрсөлдүүлэх замаар шалгарсан иргэдийн тус тусын албан тушаалд томилон ажиллуулсан.

Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд дараах мэдээллүүдийг яамны вэб хуудсанд байршуулан ажиллаж байна. Үүнд:

- Сангийн сайдын багцын жил бүрийн бараа, ажил, үйлчилгээний тайлан
- Яамны төсөв /Жилийн бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор/

			<ul style="list-style-type: none"> <li>• Яамны жил бүрийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан /Дараа жилийн 04 дүгээр сарын 01-ны өдрийн дотор/</li> <li>• Яамны сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ /Дараа сарын 10-ны дотор/</li> <li>• Яамны хөрөнгө оруулалт</li> <li>• Яамны хөрөнгө оруулалт болон орлого зарлагын гүйлгээ /Гүйлгээ хийгдэх бүрт/</li> </ul> <p><i>Мөн яамны нэгдүгээр давхарт интерактив дэлгэцийг байрлуулан дараах мэдээллүүдийг оруулан, иргэдэд нээлттэй шуурхай ажиллаж байна.</i></p> <p><i>Үүнд:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрх нээгдээд хүлээгдэж байгаа хөрөнгө оруулалтын жагсаалт</li> <li>• Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлбөрийн жагсаалт</li> <li>• Сангийн сайдын багцын 2014 оны батлагдсан төсөв</li> <li>• Сангийн яамны сар бүрийн төсвийн гүйцэтгэл</li> <li>• Сангийн сайдын 2014 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт</li> <li>• Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт</li> <li>• Сангийн сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл зэрэг болно.</li> </ul>
	<p>Төрийн захиргааны болон улс төрийн албан тушаалтнуудын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлэх</p>	<p>-Төрийн захиргааны болон улс төрийн албан тушаалтнуудын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүн тус бүрээр шалган хүлээн авах, гарын үсэг зуруулах, нэгтгэх</p> <p>-Шинээр томилогдсон буюу албан тушаал өөрчлөгдсөн төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд АТГ-т хүргүүлэх</p>	<p>“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хууль болон “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах журам”-д өөрчлөлт орж, мэдүүлгийг электрон хэлбэрээр хүлээн авах болсонтой холбогдуулан Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн програмд нэвтрэн орж, АЛБАН ТУШААЛТНЫ ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ хэрхэн бөглөх тухай гарын авлага бэлтгэсэн. Уг гарын авлага зөвлөмжийг мэдүүлэг гаргах ёстой яамны 141 ажилтан болон төслүүдийн удирдагч нар, ММНБИ-ийн удирдах ажилтнуудад элкетрон хэлбэрээр хүргүүлсэн ба мэдүүлэг гаргах ёстой албан тушаалтнууд болох 141 хүн тус бүрт зохих заавар зөвлөмж өгч, мэдүүлгийн маягтын бөглүүлэн, шалгаж, баталгаажуулж, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг АТГ-т хүргүүллээ.</p> <p>Мөн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5-д “Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн</p>




			<p>хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.” гэж заасны дагуу тус яамны төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон холбогдох материалыг хүргүүлж, дээрх нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг хэрэгжүүлэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх эсэх талаар тухай бүр хянуулан, зохих зөвшөөрөл авсны үндсэн дээр ажилд томилж байгаа болно.</p>
	<p>Яамнаас төрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд зориулсан мэдээллийн ил тод байх алхамыг тогтмол хэвшүүлж зохион байгуулах</p>	<p>Яамны нийт газрууд өөрийн газрын чиг үүрэг болон бусад холбогдох мэдээллийг тогтмол шинэчлэн мэдээлж байх.</p>	<p>Яамны чиг үүрэг болон бусад холбогдох мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн цахим хэлбэрээр болон мэдээллийн самбарыг ашиглан олон нийтэд нээлттэй, ил тод байх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.</p> <p>“Монгол Улсын Нэгдсэн Түрүүлэгч Индикатор, Засгийн газрын үнэт цаасны арилжааны мэдээ, үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлийн мэдээ” гэсэн тайлангуудын боловсруулан яамны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээллэн ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Нэгдсэн Түрүүлэгч Индикатор (НТИ) нь эдийн засаг ойрын ирээдүйд ерөнхий чиг хандлагатай харьцуулахад хэрхэн өөрчлөгдөхийг таамаглах зорилготой индикатор юм. Монгол Улсын НТИ-ыг Үндэсний Статистикийн Хорооноос зарласан Монгол Улсын улирлын ДНБ болон бусад макро эдийн засгийн үзүүлэлтүүд, Монголбанкнаас гаргасан Арилжааны банкуудын улирлын зээлийн тайлан зэргийг ашиглан сар болгон тооцоолон яамны цахим хуудсанд байршуулж олон нийтэд зарладаг. Энэ оны байдлаар нийт 10 удаа Монгол улсын Нэгдсэн Түрүүлэгч Индикаторыг тооцоолон дагалдах тайлбар тайлангийн хамт Сангийн яамны цахим хуудсанд байршуулаад байна</li> <li>2. Засгийн газрын үнэт цаасны арилжаа нь долоо хоног бүрийн гурав дах өдөр хийгддэг. Арилжааны талаар иргэд, олон нийтэд мэдээлж байх үүднээс арилжааны талаарх мэдээллийг долоо хоног бүр шинэчлэн Сангийн яамны цахим хуудсанд байршуулж байна.</li> <li>3. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн 15 дугаар зүйлийн 15.4.3-д “үнэт цаас үйлдвэрлэх” гэж, 6 дугаар зүйлийн 6.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.” гэж, 6.2-д “Тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгаж болно.” гэж тус тус заасныг үндэслэн Сангийн яамнаас Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгох хуулийн зохицуулалттай. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Үнэт цаас үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл авсан компаниудын мэдээлэл /2014 оны 3 дугаар сарын 20, 10 дугаар сарын 10-ны байдлаар/, тусгай</li> </ol>

		<p>зөвшөөрлийн тэмдэгтийн хураамжийн 2013 оны мэдээг /2014 оны 3 дугаар сарын 20/ гаргаж яамны цахим хуудсанд байршууллаа.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж танилцуулгын хамт яамны цахим хуудсанд мэдээлэхийн сацуу Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний статистикийн хороо, Үндэсний аюулгүй байдлын байнгын хороо, Монголбанк, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Төсвийн байнгын хороо зэрэг холбогдох 11 байгууллагуудад шуудангаар болон цахим байдлаар хүргүүлэн ажиллаж байна.</li> <li>- УТ-ын хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй гүйцэтгэл, түүний дараалал, санхүүжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг СМТХ-тэй хамтран яамны 1 давхарт байрлах цахим самбараар байнга мэдээлэн ажиллаж байна.</li> <li>- Яамны үйл ажиллагаатай холбоотой дүрэм журам, төсөвт байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг санхүүжилтийн болон төлбөр тооцооны журам зааврын талаарх мэдээллийг тус газрын мэдээллийн самбарт байнга байршуулан ажиллаж байна.</li> </ul>
--	--	--

#### Тулгуур 4. Хяналт шинжилгээ болон таслан зогсоох талаар

##### Зорилт 6. Авлигын эсрэг хууль тогтоомж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах

Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний тайланг тогтмол тайлагнана	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан ажил үүргийн тайланг нэгтгэж АТГ-т хүргүүлэх	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд заасан ажил үүрэг болон Авлигын эсрэг хуулийн оноосон үүргийн талаар яамны газар хэлтсүүдэд хариуцсан ажлуудын тайланг нэгтгэж АТГ-т хүргүүлж байна.
Төрийн сангийн санхүүгийн дотоод хяналт тогтмол зохион байгуулах	Аймаг нийслэлийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналт хийх	<p>Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6, 36 дугаар зүйлийн 36.6-д заасныг тус тус үндэслэн аймаг, нийслэл, төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх төрийн сангийн нэгжид дотоод хяналт хийх төлөвлөгөөг Сангийн сайдын 2014 оны 15 дугаар тушаалаар батлуулж, Төрийн нарийн бичгийн даргын 2014 оны А97 дугаар тушаалаар батлагдсан дотоод хяналтын хуваарийн дагуу Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл, Төв, Өмнөговь, Дорнод, Увс, Завхан, Ховд, Сэлэнгэ аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс, Төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх төрийн сангийн 3 нэгжид дотоод хяналтыг 2014 оны 5-11 дүгээр саруудад хэрэгжүүлж нийт давхардсан тоогоор 21 төрлийн 110 гаруй орчин зөрчил илрүүлж 260 гаруй зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.</p> <p>Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 8.2 дахь хэсэгт заасны</p>

			дагуу дотоод хяналтын тайланг нэгтгэн 2015 оны 1 дүгээр сарын 20-ны дотор танилцуулна.
Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой аливаа асуудлыг АТГ-т мэдээлэх	Авлигын сэжиг бүхий тохиолдол илэрвэл АТГ-т заавал мэдээлэх 1969 шууд утасны дугаарыг олон нийтэд ил харагдахаар байрлуулах		1969 шууд утасны дугаарыг яамны үүдэнл олон нийтэд ил харагдахаар байрлуулсан. Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигатай холбоотой аливаа асуудлыг АТГ-т мэдээлэх шаардлагатай талаар ажлын байрны тодорхойлолт дээр тусгайлсан заалт оруулсан
Дотоод аудитын тогтолцоог чадавхжуулах	Монгол Улсын төрийн сангийн мөнгөн хөрөнгийн удирдлага, Засгийн газрын өрийн удирдлагын үйл ажиллагаанд дотоод аудит явуулах, энэ чиглэлийн ажиллагсадыг мэргэшүүлэх, давтан сургалтанд хамруулж байх		<p>Тус ажлын хүрээнд <i>дотоод аудитын үйл ажиллагаа яамдын түвшинд хэрхэн зохион байгуулагдаж байгаа болон дотоод аудитын үр дүн, өгөөжийг Засгийн газарт танилцуулах зорилгоор салбарын яамдын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга нар</i>т зориулсан семинарыг 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгууллаа.</p>  <p>2014 оны 10 сарын байдлаар тус газраас дотоод аудитын Олон Улсын Стандарт, эрсдэлийн хяналтын матрицын талаарх ойлголт, дотоод аудитын бодит жишээ болон ажлын баримтан дээр хэрхэн ажиллах зэрэг нарийвчилсан 20 удаагийн сургалтаар яамд болон түүний харьяа төсөвт байгууллагуудын нийт 657 дотоод аудиторуд, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтнууд, санхүүгийн хяналт шалгалтын байцаагч, санхүү, төрийн сан, бүртгэлийн мэргэжилтнүүдэд хийгээд байна. Тус хугацаанд аймаг, орон нутагт бүсийн сургалтыг зохион байгуулсан ба нийт аймгийн 62.0 хувь буюу Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Дорноговь, Говьсүмбэр, Төв, Архангай, Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай, Баянхонгор, Увс аймгууд хамрагдаад байна.</p> <p>“Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 327 дугаар тогтоолыг батлуулсан ба энэхүү тогтоолоор Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орон нутагт төсвийн эрхийг шилжүүлж байгаатай холбогдуулан улс, орон нутгийн төсөв, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх, хариуцлагатай хяналтын тогтолцоог бүрдүүлэх</p>

		<p>зорилгоор санхүүгийн хяналт, шалгалтын чиг үүргийг бүх ТЕЗ нарт шилжүүлсэн болно.</p> <p>Үүнтэй холбогдуулан Дэлхийн банк, Жайка төслийн хүрээнд Сангийн яаманд шилжин ирсэн 11 санхүүгийн хяналтын байцаагч нарыг дотоод аудитын сургалтанд хамруулж, дотоод аудитын тогтолцоог чадавхжуулж байгаа болно.</p> <p>Мөн Сангийн сайдын 2014 оны 6 дугаар сард баталсан “Орон нутагт хийх дотоод аудитын удирдамж”-ийг дагуу Увс, Ховд, Дорнод, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул аймгуудад ЗГ-ын 147 дугаар тогтоолын биелэлт, ОНХС, ЗДНХ, ХАА болон татварын орлого бүрдүүлэлтийн явцад дотоод аудитыг тухайн аймагт байгаа дотоод аудиторудтай хамтран хийж, заавар, зөвлөгөөгөөр ханган ажилласан.</p> <p>-Дотоод аудитыг чанартай явуулсан байх</p> <p>-Дүнг Дотоод аудитын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, шийдвэр гаргуулсан байх</p>
<p>Авлигатай тэмцэх чиглэлээр холбогдох ажиллагсадыг чиглэлийн байгууллагаас зохион байгуулж байгаа дотоод гадаадын сургалтанд хамруулах</p>	<p>АТГ болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг дотоод гадаадын байгууллага, судалгааны хүрээлэнгээс зохион байгуулж байгаа богино хугацааны сургалтанд хамруулах</p>	<p>Энэ чиглэлээр холбогдох ажиллагсад сангийн яамны системийн хэмжээнд арга зүйн зөвлөгөө өгөх, эрүүгийн хэрэг маргаанд яамыг төлөөлөн оролцох мэргэшлийн бэлтгэл хангагдсан байх</p>

#### **ЭЗХЯ-наас шилжин ирсэн чиг үүргийн дагуу хийгдсэн ажлууд**

<p>9.1.4.6. Концессын зүйлийн жагсаалт болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлагдсанаас хойш ажлын 14 хоногт багтаан нийтэд мэдээлэх</p>	<p>Засгийн газрын 2013 оны 317 тогтоолоор “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ыг баталсан. Уг тогтоолыг хавсралтын хамт Эдийн засгийн хөгжлийн яамны цахим хуудас байршуулсан болно.</p> <p><a href="http://www.med.gov.mn/mn/images/kontsess/kontsessin_zuiliin_jagsaalt.pdf">http://www.med.gov.mn/mn/images/kontsess/kontsessin_zuiliin_jagsaalt.pdf</a></p>
<p>9.1.4.7.Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх</p>	<p>Концессын гэрээ байгуулсан тухай мэдээллийг яамны болон <a href="http://dnn.mn/">http://dnn.mn/</a>, news.mn зэрэг өдөр тутмын мэдээ, мэдээллийн цахим хуудсаар олон нийтэд түгээсэн болно.</p>
<p>9.1.4.8.Концессийн гэрээ байгуулсан тухай бүр концесс эзэмшигч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, концессын зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл /ажлын 14 өдрийн дотор/-ийг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байршуулах</p>	<p>Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 заасан мэдээллийг тухай бүр Эдийн засгийн хөгжлийн яамны <a href="http://www.med.gov.mn/mn/images/kontsess/kontsessin_zuiliin_jagsaalt.pdf">http://www.med.gov.mn/mn/images/kontsess/kontsessin_zuiliin_jagsaalt.pdf</a> цахим хуудаст байршуулж байгаа болно.</p>

## САНГИЙН ЯАМ